
УЛААНБААТАР
ХОТЫН
ДААТГАЛ



ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан

“Улаанбаатар хотын даатгал” ХХК

2021 он

“Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн ТУЗ-ийн

үйл ажиллагааны тайлан 2021 он

ТУЗ-ийн хурлын огноо

№	Хурлууд	Огноо
1.	ТУЗ-ийн ээлжит хурал	2021/3/24
2.	ТУЗ-ийн ээлжит хурал	2021/5/10
3.	ТУЗ-ийн ээлжит бус хурал	2021/5/12
4.	ТУЗ-ийн ээлжит хурал	2021/9/13
5.	ТУЗ-ийн ээлжит хурал	2021/10/11
6.	ТУЗ-ийн ээлжит хурал	2021/11/30

“Улаанбаатар хотын даатгал”ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2021 онд ээлжит хурлыг 5 удаа, ээлжит бус хурлыг 1 удаа зохион байгуулсан. ТУЗ-ийн хурал нь зарласан цагт эхэлсэн ба хурлын товд өөрчлөлт орсон тохиолдол байхгүй болно.

ТУЗ-ийн хурлын байршил

ТУЗ-ийн хурал нь “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн төв салбарын хурлын танхимд зохион байгуулагдсан ба товолсон байрлалд өөрчлөлт ороогүй болно.

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Ж.Самбуугийн гудамж, М Плаза оффис, 5 давхар, 500 тоот

ТУЗ-ийн хурлын агуулга, шийдвэр

1. 2021/3/24-ний өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэв.
   - “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн эрхлэн явуулж буй даатгалын бүтээгдэхүүний төрлийг батлах;
   - Даатгалын шинэ бүтээгдэхүүн боловсруулах үйл ажиллагаа, даатгалын бүтээгдэхүүнийг сайжруулахад тавигдах шаардлага зэргийг тусгасан журмын төслийг хэлэлцэх;

     Хурлын даргаас холбогдох журмыг хэрхэн хэрэгжүүлэхтэй холбоотой тодруулга авсан. ТУЗ-ийн гишүүд холбогдох журамтай танилцан санал нэгтэй баталсан.
2. 2021/5/10-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэв.

- Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын төслийг хэлэлцэх ТУЗ-ийн гишүүд холбогдох журмын төсөлтэй танилцан санал нэгтэй баталсан.

3. 2021/5/12-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит бус хурлаар дараах асуудлыг хэлэлцэв.
   - Өмгөөлөгчийн хариуцлагын даатгалын бүтээгдэхүүнийг хэлэлцэн батлах;
   - Ипотекийн даатгалын бүтээгдэхүүнийг хэлэлцэн батлах;
   - Ковид-19 цар тахлын нөлөөлөлтэй холбоотой цахимаар гэрээ байгуулах зохицуулалтыг Орон сууцны иж бүрэн даатгал, Өргөө хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүний гэрээнд өөрчлөлт оруулах.

     Хурлын өмнө даатгалын шинэ бүтээгдэхүүний гэрээ болон даатгалын гэрээнд оруулсан өөрчлөлтийн талаар “Эф Би Эл Си” ХХН-ийг гаргасан хууль зүйн дүгнэлттэй танилцаж, тодруулга авсан. ТУЗ-ийн гишүүд хэлэлцсэн асуудлыг санал нэгтэй баталсан.
4. 2021/9/13-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэв.
   - “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн хүрээнд мөрдөгдөх Ёс зүйн дүрмийн төслийг хэлэлцэн батлах.

     ТУЗ-ийн гишүүд холбогдох журмын төсөлтэй танилцан санал нэгтэй баталсан.
5. 2021/10/11-ний өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэв.
   - “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн салбарыг Багануур дүүрэгт байгуулах, салбарын удирдлагыг томилох асуудлыг хэлэлцэх;
   - “Эрүүл мэндийн даатгал”-ын бүтээгдэхүүний танилцуулга, судалгаатай танилцах, шинэ бүтээгдэхүүн гаргах эсэхийг шийдвэрлэх;
   - “Орон сууцны иж бүрэн даатгал”-ын актуар тооцоололтой танилцах, хураамж болон даатгалын гэрээнд өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэх.

     Хурал эхлэхийн өмнө ТУЗ-ийн гишүүд нь Багануур салбарын удирдлагад санал болгож буй даатгалын мэргэжилтний анкет, даатгалын бүтээгдэхүүн борлуулах төлөвлөгөөтэй танилцсан. ТУЗ-ийн гишүүд санал нэгтэйгээр хэлэлцсэн асуудлыг зөвшөөрч, холбогдох өөрчлөлтүүдийг баталсан.
6. 2021/11/30-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэв.
   - “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцэх;

     ТУЗ-ийн гишүүд төлөвлөгөөтэй танилцан санал нэгтэй баталсан.

ТУЗ-ийн хурлаар батлагдсан хавсралт

1. “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн даатгалын бүтээгдэхүүний төрөл - Хавсралт №01
2. “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн даатгалын бүтээгдэхүүн боловсруулах журам - Хавсралт №02
3. “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам - Хавсралт №01
4. “Өмгөөлөгчийн хариуцлагын даатгалын нөхцөл” – Хавсралт №01
5. “Өмгөөлөгчийн хариуцлагын даатгал хийх журам” – Хавсралт №02
6. “Өмгөөлөгчийн хариуцлагын даатгалын гэрээ” – Хавсралт №03
7. “Ипотекийн амь нас, эрүүл мэндийн даатгалын нөхцөл” – Хавсралт №04
8. “Ипотекийн амь нас, эрүүл мэндийн даатгалын журам” – Хавсралт №05
9. “Ипотекийн барьцаа хөрөнгийн даатгалын нөхцөл” – Хавсралт №06
10. “Ипотекийн барьцаа хөрөнгийн даатгалын журам” – Хавсралт №07
11. “Ипотекийн даатгалын гэрээ” – Хавсралт №08
12. “Орон сууцны иж бүрэн даатгалын гэрээ” – Хавсралт №09
13. “Өргөө хүртээмжтэй даатгалын гэрээ” – Хавсралт №10
14. “Ёс зүйн дүрэм” – Хавсралт №01
15. “Нийтийн болон хувийн орон сууцны даатгалын нөхцөл” – Хавсралт №04
16. “Нийтийн болон хувийн орон сууцны даатгалын журам” – Хавсралт №05
17. “Орон сууцны хариуцлагын даатгалын нөхцөл” – Хавсралт №06
18. “Орон сууцны хариуцлагын даатгалын журам” – Хавсралт №07
19. “Орон сууцны иж бүрэн даатгал”-ын гэрээ - Хавсралт №08
20. “Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө - Хавсралт №01